



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/127

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, эрх сэргээх,
хэсэгчлэн хүчингүй болгох
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.4, 10.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.22, 19.23 дахь заалт, Эрүүл мэндийн яамны “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс”-ын 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, эрх сэргээх байгууллагын нэрсийг хоёрдугаар, хэсэгчлэн хүчингүй болгох байгууллагын нэрсийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ


080555

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
0.3 сарын 19... өдрийн 1/13 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР БОЛОН НЭМЭЛТЭЭР ОЛГОХ
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
Шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	ЭМ-Ж-Ж-ЭМ ХХК	Эмнэлгийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл протез импортлох ханган нийлүүлэх	3 жил
2	Томи Протейн ХХК	Биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил
Нэмэлтээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
3	Ган-Эм Фарм ХХК	Биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
03 сарын 19 өдрийн 1 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СЭРГЭЭХ
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	Миракл медиа ХХК- ний Миракл клиник	Эрэгтэйчүүд, арьс гоо засал, уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ
2	Найдвар Хоспис ХХК- ний Найдвархоспис эмнэлэг	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ
3	Рэндэжиүтай Очирваань ХХК	Уламжлалт, дотор, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, проктологийн тусламж үйлчилгээ

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
03. сарын 19. өдрийн 21/дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХЭСЭГЧЛЭН ХҮЧИНГҮЙ БОЛГОХ
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	Рэндэжиүтай Очирваань ХХК	Мэдрэлийн өвчний оношлогоо, эмчилгээ
2.	Миракл медиа ХХК	Сэргээн засах тусламж үйлчилгээ